

ДУРТГАЛ,
ТЭМДЭГЛЭЛ

ӨВӨР МОНГОЛ ОРНООР

(Замын тэмдэглэл)

Нэг.

Би 1950-иад оны үед БНХАУ-ын нийслэл Бээжин, Нанжин, Шанхай, Сиан зэрэг газруудаар явж хятадын ард түмний олон мянган жилийн соёл урлагийн дурсгалт зүйл, түүхэнд алдаршсан хот суурингуудаар ихийг үзэж билээ.

БНХАУ-ын улс төр, эдийн засаг, соёл урлаг, эрдэм шинжилгээний алдарт зүтгэлтнүүд Чжоу-энь-лай, Пэн-жэн, Улаанхүү, Сүн-Ци-Лин, Ма-чин, Мао-дун, зохиолч эмэгтэй Дин-лин, Ли-да-чан (генерал Фыньюшенийн гэргий), алдарт жүжигчин Ми-лин-фань зэрэг хүмүүстэй олонтаа уулзаж тэр орны талаар нэлээд ойлголцтой болсондоо сэтгэл хангалуун байдаг юм. Гэвч манай ард түмний нэгэн угсаатны оршдог Өвөр Монгол орноор эдүгээ хүртэл явж уг орны байдалтай танилцах бололцоогүй явсаар ирсэн. 1989 онд Өвөр Монголын өөртөө засах орны засгийн газрын дэмжлэгээр Өвөр Монголын их сургуулийн эрдэмтдийн урилгаар очих болов, тэр ёсоор тэр оронд энэ 1990 оны 10-р сард хоёр долоо хоног шахам айлчилж их зүйлийг үзэх аз завшаан надад тохиолдов. Өвөр Монголчууд өөрийнхөө орныг «Үзэсгэлэнт сайхан өнөр баялаг орон» хэмээн лавлах бичигтээ оновчтой тодорхойлжээ.

1947 оны 5-р сарын 1-нд байгуулагдсан Өвөр Монголын өөртөө засах орон нь БНХАУ-ын салшгүй хэсэг бөгөөд 1 сая 200 мянган хавтгай дөрвөлжин км газартай, 20 гаруй сая хүн амтай, түүний дотор 2 сая хагас монголчууд оршин суудаг үндэстний анхны томоохон өөртөө засах орон юм. Энэ орны засаг захиргааны байгуулалт нь 8 аймаг, 4 хот, 101 хошуу тосгон зэрэг нэгжээс бүрэлдэж хятад, монгол, хотон, манж, солонгос, дагуур, хорчин зэрэг 10 гаруй үндэстэн ах дүүгийн найрамдалтай амьдран сууцгааж байна. Өвөр Монгол орон өндөр уулс, шигүү ой, өргөн тал, цөл говь, хатан гол хэмээх урт өргөн шар мөрөн, нуур, цөөрөмтэй, малын тэжээлийн ургамлаас гадна үр тариа, зүйл бүрийн нарийн ногоо, жимс, жимсгэнэ ургуулдаг эрдэс баялаг ихтэй орон юм.

Тус оронд төмрийн хүдэр, нүүрс, чулуун тосны (нефть) уурхай зэрэг байгалийн баялаг ихтэй орон. Улс орны эдийн засгийн тоо баримтыг нарийн үзэж танилцаагүй болохоор зөвхөн дээрхийг дурьдав. Өөртөө засах орон байгуулагдсанаас хойш энд нутагладаг монгол болон бусад үндэстний соёл урлаг, хэл бичиг, түүх, зан заншил сэргэн мандаж сургууль соёл нь хөгжиж ирснийг нүдээр үзэж танилцан мэдэв.

Хоёр.

Би цөөхөн хоногийн хугацаанд Хөх хот, түүний тойрог, ордос багуутын нутгаар машинаар аялан ихээхэн зүйлийг үзэв. Хөх хот нь зүүнээс баруун тийш хэдэн арван км үргэлжилсэн далан хар уул хэмээх давхарласан өндөрлөгүүдийн өмнөх уудам хөндийд оршино. Энэ хөндийд таримал модон ой, жимс, жимсгэнэ, ногоо, тариан талбай элбэг бөгөөд энэ ажлыг эрхлэн явуулдаг олон тосгон, тоосго шавар байшинтай айлууд өдий төдийгөөр шигүүвтэр нутаглана. Хонин сүрэг хариулж яваа монгол хүмүүс, хааяа хятад малчин тааралдах нь сонин ч юм шиг байв.

Хөх хот нь 17-р зууны дундаас байгуулагдаж Түмд угсаатны улс төр, эдийн засгийн нэгэн томоохон төв болж, анхны буддагийн шашны алдарт хүрээ (их зуу) 1579 онд эхлэн баригдаж Түмдийн алтан хааны

ууган хүү Сэнгэ Дүүрэн, 3-р далай лам Содномжамцыг Хөх хотод залж бурхан солнгос сургаалын номыг айлдуулснаас гадна 1652 онд 5-р далай лам Түвдээс Бээжинд залрах зуураа энд үдэлж ном айлджээ. Хийдийн барилга нь хийц урлаг гойд сайхан, тэнд хадгалагдаж буй 108 боть Ганжуур зэрэг түүх, соёлын үнэт өвтэй. Энэ сүмийг 1986 оноос засгийн газар чухал дурсгал хэмээн улс өөрийн хамгаалалтанд авсан байна.

Хөх хотод Мандухай сэцэн хатан амьдарч байсан болохоор түүний нэрэмжит их цэцэрлэг байдгийг үзлээ. Хөх хотын таван суврага, бага зуу, улсын музей зэргээр явж танилцахад Өвөр Монголын соёл урлагийн түүх, олон үндэстний зан заншлыг таньж мэдэх бүрэн бололцоотой байв.

Хөх хотын бас нэг үзвэрийн газар бол монгол үндэстний орчин үеийн бараа таваарын их дэлгүүр юм. Энэ нь худалдаа арилжааны газар боловч хэрэг дээрээ монгол угсаатнууд урьд өмнө эдэлж өмсөж хэрэглэн ирсэн зүйлсээ тус бүрийн өвөрмөц аргаар сэргээн үйлдэн тавьсан олон улс үндэстний соёлын нэгэн чухал музей мэт харагдана.

Хөх хот нь хуучин шинэ хэмээн хоёр хэсэгт хуваагдах боловч хуучин хэсэгт нь сүм дуган, хэрэм хашаа, хөх тоосгон байшин бүхий хэдэн гудамжаас бүрэлдэнэ. Харин шинэ хэсэгт нь Өвөр Монголын их сургууль, багшийн их сургууль, театр, соёлын орднууд, Өвөр Монголын өөртөө засах орны засгийн газрын харш зэрэг олон давхар орчин үеийн сайхан барилгууд сүндэрлэн боссон урт гудамж, өргөн талбай, ой, цэцэрлэг ихтэй юм. Хөх хот нь 700 гаруй мянган хүн амтай гэхэд гудамжаар зорчигч машин цөөвтөр юм шиг харагдах нь машин хэрэглэх чадваргүйдээ биш, бензин тос хэмнэх, хотын агаарыг цэвэр тунгалаг байлгах, иргэдийнхээ эрүүл мэндэд туслах зорилгоор голдуу унадаг дугуйг ихээхэн хэрэглэнэ. Энд унадаг дугуйны өөрийн үйлдвэртэй юм байна. Дугуй машинаар явагчид хөдөлгөөний дэг сайтай, явган хүмүүс нь машинд зам чөлөөлдөг нь таатай санагдав. Үүнээс надад төрсөн сэтгэгдэл гэвэл манай улс шиг мал сүрэгтэй, олон зуун мянган морьтой орны нийслэл, хот, суурин, сумын төв ч гэсэн хөнгөн морин тэрэгний таксины үйлчилгээ байгуулж, цөн, шариг, төмөр, резин хэрэглэн дугуйг хөнгөвчлөн хөдөлгөөнийг түргэлэхүйц, бүрхүүл бүхий хөнгөн тэрэг үйлдвэрлэж хот суурины хүмүүсийг үйлчилвээс бензин хэмнэж, агаарыг цэвэр байлгаж ард олныхоо заншилт уламжлалыг сэргээхэд хичнээн ашигтай болох билээ гэж бодогдов. Хотын дэлгүүрт тавьсан бараа нь нээлттэй хаалгын шугамаар оруулж ирсэн зүйлээс гадна өөрийн орны түүхий эд, бас хоёрдогч түүхий эдийг ашиглан мянга түмэн төрлийн бараа үйлдвэрлэн олондоо үйлчилж байна. Үүнийг үзэхэд манайд хаягдал болсон хагархай шил дахин хайлуулж гоё хийцтэй сав, элдэв эдлэл хийх их бололцоо байгаагаас эхлэн бид зөндөө юм санаачилмаар юмдаа гэлтэй.

Бид Хөх хотоос баруун тийш ордосын өргөн их цөл газар барьж босгосон Чингисийн онгоныг үзэх замдаа Өвөр Монголын эртний алдарт хүрээ хийдийн нэг болох хадархаг хавцалд хад хясаа түшүүлэн барьсан уран хийцтэй дацан дуган бүхий Бадгар зуу хэмээх нэгэн сайхан хүрээг үзэж түүний зарим дуганд явагдаж байсан хурал номын газраар орж сэтгэл зүрхээрээ хүндэтгэж явлаа. Энэхүү дуган нь өөрийн онцлог түүхтэй боловч тавиад оны сүүлч, жараад оны эхээр нугалаатны зүгээс хэлмэгдэж эвдэрсэн хэдий авч одоо түүнийг засан сэргээж хуучин байдалд нь бүрэн оруулсан нь аятайхан харагдана. Мөн баруун Түмдийн төв Дун шан хэмээх авсаархан бөгөөд цэврийн цэвэрхэн хотод үдлэн хоноглож буцах замдаа нэг сая гаруй оршин суугч-

тай төмрийн хүдрийн уурхайн төв Бугат хотноо амарч дээрх газруудын түүхэн ба орчин үеийн байдалтай нэлээд дэлгэрэнгүй танилцав.

Өвөр Монголын их сургуулиас төлөвлөсний дагуу Чингисийн онгон шүтээнд хүрч мөргөв. Энд одоогоос 300 гаруй жилийн өмнө найман цагаан гэрийг барьж их тайлга үйлдэж Чингисийн эдлэл, хэрэглэл, домог, дурсгалт зүйлийг нандигнан хадгалж ирснээр БНХАУ-ын төрийн зөвлөл 1954 онд шийдвэр гаргаж тэр буянт үйл явдалд ихээхэн хэмжээний мөнгө хөрөнгийг зарцуулан Өвөр Монголын өөртөө засах орны тэргүүн улс төрийн зүтгэлтэн, хувьсгалч Улаанхүүгийн идэвхтэй оролцоогоор босгон барьжээ. Ордосын их манхан цөлийн нүүмэл элсийг эндхийн хүмүүс ихээхэн хөдөлмөр гарган ой шугуйгаар чөдөрлөн тогтоож тохижуулсан байна. Тэнд Чингисийн гурван их дуган Гандирийн шил хэмээх газар таван түмэн таван мянга гаруй тэгш дөрвөлжин метр газар салаавчлан байгуулж, төрөл бүрийн модоор бүрэлдсэн том цэцэрлэгтэй юм. Энэхүү онгоны гурван сүмийн дээврийг монгол гэрийн хэлбэрийг дуурайлган босгожээ. Тэрхүү гэрийн хэлбэртэй дээврийн орой бүхий гурван ордыг нэг метр өндөр суурин дээр байршуулан гол, урд, баруун, зүүн жигүүрийн ордон ба зүүн баруун гудас гэж зургаан хэсгээс бүрэлдүүлэн барьжээ. Гол ордон нь 24 метр өндөр, түүний жигүүрийн хоёр ордон тус бүр 18 метр өндөр бөгөөд хар, хөх шаазан ваараар цомцоглон дээвэрлэжээ. Гол ордоны их хаалганы дэргэдэх саравчны тэг дунд «Чингис хааны онгон» гэж алтан үсгээр бичжээ. Энэ онгон нь БНХАУ-ын нэг чухал дурсгалт зүйл хэмээн тунхаглан зарлагдсан байна. Гол ордоны дотор гантиг чулуугаар сийлэн босгосон Чингисийн дүр бүхий том хөшөөний өмнө монголын заншил ёсоор цай, хадаг, цагаан идээ, сархадыг өргөн барихад хэдэн хүмүүс байх бөгөөд Дархад гэж эртнээс алдаршсан 500 хүнээс үлдсэн эртний ёслолыг хүндэтгэн явуулдаг монгол дээлтэй дөрвөн залуу Чингисийн онгонтой холбоотой ерөөлийг аялан уншив. Тэгэхэд Чингисийг судалдаг газрын орлогч дарга Шаралдай бүх ёслолыг удирдаж байв. Энэ ёслолын дараа би гурван ордонд байрлуулсан хар, цагаан туг, Чингис ба түүний ойр дотнын хүмүүсийн хэрэглэж байсан эдлэл зэргийг үзэж ордоны хэрэм доторхи монголчуудын зан заншлыг харуулсан гэр, харш зэрэг дурсгалт зүйлс, газруудтай танилцав.

Гурав.

Би Өвөр Монголын сурлага хүмүүжил, эрдэм шинжилгээний ажилтай нэлээд дэлгэрэнгүй танилцав. Өвөр Монголын их сургууль нь 1957 онд байгуулагдаж анхны захирлаар нь Улаанхүү дарга удаан хугацаагаар ажиллаж дараа нь түүнтэй хамт зүтгэлцсэн, нэрд гарсан эрдэмтэн профессор Чингэлтэй, Босян, Түвшин, Буянхишиг, Чойжинжав, их, бага Баатар зэрэг хүмүүс тэнд удирдах ба багшлах ажлыг олон жил хийж эрдмийн их бүтээлийг туурвин байна. Эдүгээ их сургууль нь монгол хэл бичиг, хятад хэл бичиг, түүх, гүн ухаан, эдийн засаг, хууль зүй, гадаад хэл бичиг зэрэг олон тэнхмүүдтэйгээс гадна хөдөө аж ахуйн судалгааны төв, тоо, онолын физик, эрчим хүч, хими, биологи зэрэг чиглэлээр эрдэм шинжилгээний ажил явуулдаг хүрээлэнгүүдтэй юм. Их сургууль баялаг номын сантай, хэл бичгийн судалгаанд тооцоолон бодох техникийг чадамгай хэрэглэж байна.

Өвөр Монголын багшийн их сургууль нь 1952 онд байгуулагдсан бөгөөд энд сурган хүмүүжүүлэх ухаан, монгол хэл бичиг, хятад хэл бичиг, түүх, гадаад хэл бичиг, урлаг, тоо, физик, хими, биеийн тамир зэрэг мэргэжлээр дунд сургуулийн багш нар бэлтгэнэ. Дээрх хоёр дээд сургуульд Марксизм, Ленинизм, улс төр эдийн засгийн ухаан зэрэг онол улс төрийн хичээл зааж байна. Сургуулиудын байшин барилгыг үйлчилгээ хүмүүжлийн үүднээс маш нарийн төлөвлөн барьж байгуулжээ. Жишээлэхэд: Хоёр сургууль тус бүр ихээхэн хэмжээний талбай эзэлж, ой мод, нуур цөөрөм байгуулж, багш нарын орон сууц, оюутны нийтийн байр, номын сан, соёлын төв, хоолны газар, эмнэлэг, биеийн тамирын талбай зэргийг нэгэн доор байгуулсан нь багш оюутан ажилчдад үйлчлэхэд дөхөм хялбар тэдний хоорондын холбоо харилцааг бэхжүүлэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэж байгаа нь Англи, Францын их сургуулиудын барилгын зохион байгуулалтыг санагдуулна. Өвөр Монголын багшийн сургууль нь Их сургуулийнхаа нэгэн адил эрдмийн бүтээл ихээр явуулж, багшлах ба эрдэм шинжилгээний ажил явуулах боловсон хүчнийг бэлтгэдэг ажээ.

Багшийн сургуулийн Хэвлэн гаргасан «Хууль зүйн бичиг» хоёр боть, Ойрадын түүхэн сурвалж бичиг, Хөх хотын түүхийн зургаан боть зэрэг номыг надад бэлэглэснээс гадна их сургуулийн багш профессор Чингэлтэй бүтээлийнхээ олон дээжээс, Боошин багш хэлний шинжлэлийн удиртгал хэмээх номоо дурсган хайрласан нь хамгийн үнэт бэлэг билээ. БНХАУ түүний дотор Өвөр Монголын өөртөө засах оронтой манай орны харилцаа сэргэн өргөжиж байгаа нь эдгээр орны хөгжлийн туршлагыг судлахад бидэнд таатай нөхцөлийг бий болгож байна.

БНМАУ-ын ерөнхийлөгч П.Очирбат БНХАУ-д зочлон Өвөр Монголын өөртөө засах оронд айлчилсан хийгээд БНХАУ-ын нам төр, соёлын зүтгэлтнүүд тухайлбал Өвөр Монголын өөртөө засах орны дарга Бөхөө манай оронд айлчилсан нь тус хоёр хөрш орны уламжлалт найрамдал, хамтын ажиллагааны хөгжилд ихээхэн ач холбогдолтой боллоо. Эдүгээ тус хоёр орны иргэд нааш цааш ирж очих нь улам өргөжин ихэссээр байна.

Монголчууд бид хөрш БНХАУ, Өвөр Монголын өөртөө засах оронд айлчлан очихдоо үзмээр, сурмаар зүйл их харагдана. Жишээ нь: Малчид, хөнгөн хүнсний үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилчдын санаачлагыг дэмжин хөхүүлж буйн ачаар бараа таваар, гадаад улстай солилцох, улс орондоо үйлдвэрлэн боловсруулах, мал аж ахуйгаа өсгөн хөгжүүлэх, үр тариа, хүнсний ногоо, ялангуяа нарийн ногоо, жимс жимсгэнийг тарьж ургуулах гарамгай туршлагаас суралцахыг манай иргэд урьтал болгон энэ оронд айлчилж байх нь юуны өмнө чухал мэт санагдана. Түүнчлэн түүх соёлынхоо өвийг судалж сэргээн хөгжүүлэхэд гаргаж байгаа нааштай талыг ч бид нэгэн адил анхааран суралцах нь нэн тустай болно. Өвөр Монгол оронд очиход намайг халуун дотно хүлээн авч улс орныхоо түүх дурсгал, орчин үеийн амьдралыг дэлгэрэнгүй танилцуулж өгсөн явдалд тэр нөхөддөө чин сэтгэлийн талархал илэрхийлье.

АКАДЕМИЧ Б. ШИРЭНДЭВ